

тогтвортой байдал, шинэлэг арга хандлага, бодлогын болон бүтцийн санаачлагад тусгайлан ач холбогдол өгсөн байна. Хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах явцад ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээний үнэлгээг хийх, үндэслэлийг нь батлахад ашиглах боломтой хэд хэдэн аргыг судалж үзсэн байна. Эдгээр нь эрсдлийн удирдлага, “Хамгийн бага-Зардал-Нэмэх-Алдагдал” зарчим², төсвийн түвшингийн сонголт зэрэг болно.

Хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулахад ашигласан арга хандлагуудаас гадна загвар төслүүдийн бодит хэрэгжилтийн үед авч хэрэглэх арга хандлагуудыг мөн тодорхойлсон байна. Эдгээрийн нэг нь ШШШ-ны асуудлыг өмнөх туршлага дээрээ үндэслэн шийдвэрлэхийн зэрэгцээ шинэ болоод шинэлэг арга хандлагуудыг бий болгох явдал байсан бол өөр нэг нь анхаарал хандуулах нутгуудын сонголт болон шилдэг практик туршлагуудыг тодорхойлоход хувь хүмүүс, өрх, нутгийн оршин суугчид, хувийн хэвшлийнхэн, эрдэмтэд, Засгийн газрын янз бүрийн түвшний агентлагууд, олон улсын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж байв.

² Ойн түймэртэй тэмцэх менежментийн хөтөлбөрт хэрэглэгддэг энэхүү загвар нь ШШШ мэтийн хөнөөлт үзэгдлийн тодорхой бус байдал болон өргөн хүрээтэй хор уршигтай тэмцэх арга хэмжээнүүдийн өртөг үр дүнг үнэлэх нэгэн арга юм.